

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 22
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	23 – 78
1.	<i>Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлт</i>	24 – 26
2.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	27 – 41
3.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	41 – 71
4.	<i>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	71 – 78

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 07 дугаар сарын 02-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 56 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Болормаа, Г.Дамдинням, П.Мөнхтулга, Б.Түвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: З.Мэндсайхан.

Нэг.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалт, удирдлага арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татварын ерөнхий газрын Татвар төлөгчдөд үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Бат.Баярмаа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 13 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын Татвар хураалт, удирдлага арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татварын ерөнхий газрын Татвар төлөгчдөд үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Ж.Түвшинжаргал, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс болон Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс болон Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Н.Наранбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Төслийн 1 дүгээр зүйлийн 1.12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт “12.1.24.тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг орон нутгийн ерөнхий орлогын данснаас татан төвлөрүүлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс болон Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Б.Баярбаатар, Ш.Бямбасүрэн, Д.Ганбат, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, М.Нарантуяа-Нара, Д.Пүрэвдаваа, П.Ганзориг, Да.Цогтбаатар, Б.Уянга, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс болон Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

- “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

-Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их

Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

- ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

-Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан хариулж, тайлбар хийв.

-Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын ““Алт-3” аяныг 2025 оны ... дугаар сарын ... өдрөөс эхлэн орон даяар зарлан хэрэгжүүлсүгэй” гэснийг “дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтын ““Алт-3” аяныг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарт даалгасугай. Үүнд:” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтад “эрх, үүргийн харилцааг тодорхой болгож,” гэсний дараа “төсөл хэрэгжиж байгаа суманд үр өгөөжийн дийлэнхийг үлдээж” гэж нэмэх, мөн дэд заалтын “эрх зүйн орчныг өөрчлөх” гэснийг, “эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж өөрчилж, мөн дэд заалтын “арга хэмжээ шуурхай авах” гэснийг, 3 дахь дэд заалтын “арга хэмжээ авах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 4 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж нэмж, мөн заалтын “алтны” гэснийг, мөн дэд заалтын “батлуулах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтын “эргэлтэд оруулах” гэсний дараа “зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” 46, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 47 дугаар тогтоолын холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Тогтоолын төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтад заасан нөхцөлийг хангах үүднээс хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид учирч буй хүндрэл, үүний дотор газар ашиглахтай холбоотой асуудлыг судлан, эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 11
Бүгд: 18
38.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3, 4 дэх заалт нэмэх:

“3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

- Найруулгын санал.

Ц.Даваасүрэн: 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөлгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Төрмөнх, Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын тавьсан асуултад Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.АЖЛЫН ХЭСГИЙН САНАЛ

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн зардал хооронд зохицуулалт хийх санал:

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

1.1. Зардал бууруулах санал:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг **2,600.0 сая** төгрөгөөр;
- Дэд сайдын томилгоог хойшлуулахтай холбоотойгоор урсгал зардлыг **2,189.7 сая** төгрөгөөр;
- Сангийн сайдын төсвийн багц дахь Засгийн газрын нөөц сангийн зардлыг **16,336.9 сая** төгрөгөөр;
- Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зарлагын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.3 хувиар буюу **30,649.0 сая** төгрөгөөр тус тус бууруулан, эдгээр эх үүсвэрээр дараах арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх. Үүнд:

1.2. Урсгал зардал нэмэгдүүлэх санал:

- Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас татаж авсантай холбогдуулан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг **1,144.0 сая** төгрөгөөр;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн урсгал зардлыг **1,000.0 сая** төгрөгөөр;
- Гэр бүл, хүүхдийн хэрэг маргааныг шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүхийг шинээр байгуулах бэлтгэл ажлыг хангахад шаардагдах зардалд зориулж Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг **12,581.5 сая** төгрөгөөр;
- Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд Монголын талын хариуцах зардал буюу Монгол-Германы хамтарсан Технологийн дээд сургуулийн татаасыг **517.5 сая** төгрөгөөр, Монгол-Япон эмнэлгийн татаасыг **1,600.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн Боловсролын сайдын төсвийн багцын урсгал зардалд нийт **2,117.5 сая** төгрөгийг нэмж тусгах;
- Мөнгө угаах, хөрөнгө буцаах, үндэстэн дамнасан болон авлига албан тушаалын хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой болон прокурорын байгууллагын гэрээгээр хүлээсэн зарим зардлыг санхүүжүүлэхэд зориулж Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын урсгал зардлыг **1,307.9 сая** төгрөгөөр;
- “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг нэмэгдүүлнэ” гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн урсгал зардлыг **458.0 сая** төгрөгөөр;

- 2025 оноос хос бичигт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны урсгал зардлыг **936.7 сая** төгрөгөөр;
- Говийн бүс нутгийг усжуулах, усан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд хийгдэх судалгаа, шинжилгээний төслийн нэгжийн зардлыг **230.0 сая** төгрөгөөр;
- Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн үйл ажиллагааны урсгал зардалд зориулж Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын урсгал зардлыг **1,000.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

1.3. Хөрөнгийн зардал нэмэгдүүлэх санал:

- Төслийн 2 дугаар хавсралтын ХХ.3.2-т тусгагдсан “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг **19,000.0 сая** төгрөгөөр;
- Төслийн 2 дугаар хавсралтын ХII.1.3.2-т тусгагдсан “Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг **7,400.0 сая** төгрөгөөр;
- Төслийн 2 дугаар хавсралтын ХI.1.1-д тусгагдсан “Гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах /Баруун бүс/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг **4,600.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.2025 оны төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдүүлэх санал:

Ц.Даваасүрэн: 1.Төслийн 2 дугаар хавсралтын ХХVII.1.9-д тусгагдсан “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 36,134.9 сая төгрөг, санхүүжих дүн 18,184.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **1,721.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Хоёр.БУСАД БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН САНАЛ

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.3.1.1 дэх дэд заалтын “Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдах хүн” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин “100,000” гэснийг “15,000” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.3.2 дахь заалтад тусгагдсан “Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг сайжруулна.” гэсэн хөтөлбөрийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.4.1.1 дэх дэд заалтын “Зорилтот бүлгийн залуучуудын нийгмийн оролцоо, үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.” гэсэн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин “46 хувь” гэснийг “30 хувь” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Хэрлэн нарын гаргасан, Боловсролын сайдын төсвийн багцын урсгал зардлын Бараа үйлчилгээний бусад зардлыг **5,800.0 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Төрийн өмчит их, дээд сургуульд олгох татаасыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 15
Бүгд: 18
16.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Гурав.ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН САНАЛ

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.045 хувиар буюу **4,500.0 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр дараах төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг нэмэгдүүлэх. Үүнд:

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг **2,000.0 сая** төгрөгөөр;
- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын урсгал зардлыг **1,500.0 сая** төгрөгөөр;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын Биеийн тамир, спортын улсын хорооны Монгол Улсад зохиогдох олон улсын тэмцээний зардлыг **1,000.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 15
Бүгд: 19
21.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын судалгааны зардлыг **2,900.0 сая** төгрөгөөр буруулж, мөн дүнгээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцын Усны газрын урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцын Ойжуулалтын хөтөлбөрийн зардлыг **2,990.0 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр тус сайдын төсвийн багц дахь Усны нөөц, нуур, гол мөрний менежментийн хөтөлбөрийн зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 16
Бүгд: 19
15.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Боловсролын сайдын төсвийн багцын Нийслэлийн боловсролын газрын урсгал зардлыг **2,600.0 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 15
Бүгд: 19
21.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Б.Пүрэвдорж нарын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг **84.6 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын урсгал зардлыг **3,700.0 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтад “Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/ төслийн нэмэлт санхүүжилт”, төсөвт өртөг, санхүүжих дүн **3,700.0 сая** гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19
36.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг **1,781.1 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.12.Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19
36.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.01 хувиар буюу **1,000.0**

сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын Биеийн тамир, спортын улсын хорооны Монгол Улсад зохиогдох олон улсын тэмцээний санхүүжилтийг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих татаас, урамшуулал”-ыг **15,000.0 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр тус сайдын төсвийн багцын “Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалтын сан”-гийн төсвийг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10. Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын урсгал зардлыг **2,976.0 сая** төгрөгөөр бууруулж мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтын IV.2.3.1-д тусгагдсан “Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 14

Бүгд: 19

26.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

11. Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг **50,000.0 сая** төгрөгөөр бууруулж, төсвийн тэнцлийг сайжруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 17
Бүгд: 19
10.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

12.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын урсгал зардлын гадаад томилолтын зардлыг **1,212.2 сая** төгрөгөөр бууруулж, төсвийн тэнцлийг сайжруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 17
Бүгд: 19
10.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

13.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын “Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны зардлыг **400.0 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19
36.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

14.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх, мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацааг саналын томьёололд нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Төрмөнх, Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/ 2026 онд “5.7” гэснийг “6.0” хувь гэж, 2027 онд “6.3” гэснийг “6.5” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “31,720.4” гэснийг “33,479.5” гэж, 2027 онд “33,761.0” гэснийг “35,628.6” гэж, Дотоод эдийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “30.9” гэснийг “31.7” гэж, 2027 онд “29.3” гэснийг “30.4” гэж, Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “32,839.8” гэснийг “33,479.5” гэж, 2027 онд “34,626.0” гэснийг “35,628.6” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь 2026 онд “32.0” гэснийг “31.7” гэж, 2027 онд “30.0” гэснийг “30.4” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ 2026 онд “-1,1” гэснийг “0” гэж, 2027 онд “-0.7” гэснийг “0” гэж, Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “29,666.4” гэснийг “30,314.5” гэж, 2027 онд “31,452.6” гэснийг “33,282.2” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “28.9” гэснийг “28.7” гэж, 2027 онд “27.3” гэснийг “28.4” гэж, Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/ 2026 онд “2,054.0” гэснийг “3,165.0” гэж, 2027 онд “2,308.4” гэснийг “2,346.4” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “2.0” гэснийг “3.0” гэж, Засгийн газрын өрийн нийт хэмжээ “тэрбум

төгрөг/ 2026 онд “51,350.0” гэснийг “52,750.0” гэж, 2027 онд “51,939.0” тэрбум гэснийг “52,794.0” гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “2.6” гэснийг “2.5” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 6

Бүгд: 19

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс болон Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөл тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 5

Бүгд: 19

73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 14 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 56 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны хуралд оролцох ёстой 25 гишүүнээс 13 ирсэн. 52.0 хувийн ирцтэй байгаа учраас Төсвийн байнгын хорооны 2025 оны 07 сарын 02-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаанд Д.Батбаяр гишүүн, Д.Батлут гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Х.Ганхуяг гишүүн, Д.Цогтбаатар гишүүн, Р.Батболд гишүүн, Б.Батцэцэг гишүүн, Г.Ганбаатар гишүүн, Ц.Даваасүрэн, Ж.Батжаргал гишүүн, Ж.Баясгалан гишүүн П.Ганзориг гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн нар хүрэлцэн ирсэн байна.

Ингээд 4 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Нэг.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гарсан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлт танилцуулна.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийнэ.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг хийнэ.

Энэ гол хэлэлцүүлэг байгаа.

Дөрөв.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа тогтлоо.

Эхнийхээ хэлэлцэх асуудал руу оръё.

**Нэг.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан
иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн
санал, дүгнэлт**

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж 100 мянга гаруй иргэдээс гаргасан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д заасан орлогод ногдох албан татварын хэмжээг 1 хувь болгож бууруулах талаарх нийтийн өргөдлийг Төсвийн байнгын хорооны 2025 оны 04 сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дээрх өөрчлөлтийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Одоо ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэнэ.

Энэ асуудлыг хэлэлцэхэд оролцож байгаа ажлын хэсгийг би Та бүхэнд танилцуулъя.

Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ч.Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалт, удирдлага арга зүйн газрын дарга, Б.Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчдөд үйлчлэх газрын дарга гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг танилцуулна.

Санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан байгаа.

Х.Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр иргэн н.Шинэгэрэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д заасан орлогод ногддог албан татварын хэмжээг 1 хувь болгож бууруулах асуудлаар хуулийн төсөл санаачлах өргөдлийг үүсгэн, уг өргөдлийг 100 мянга 187 иргэн гарын үсэг зурж дэмжсэн

асуудлыг Төсвийн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 292 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт өргөдлийг шилжүүлсэн.

Ажлын хэсэг иргэний гаргасан өргөдлийн асуудлаар онол, практикийн түвшинд нарийвчлан судалж, хувь хүний албан татвартай холбогдох хууль тогтоомж, харьцуулсан судалгаа, лавлагаа, мэдээлэл болон олон улсын байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмжтэй танилцлаа.

Хувь хүний орлогын албан татварын хууль нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулж байх бөгөөд хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтаар татвар ногдуулах 6 эх үүсвэрийг тусгасан байна. Үүнд:

1.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээрт дайтагдах хөдөлмөр эрхлэлтийн орлого.

2.Үйл ажиллагааны орлого.

3.Хөрөнгийн орлого.

4.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого.

5.Шууд бус орлого.

6.Бусад орлого.

Хувь хүний орлогын албан татвар нь эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг дэмжих, өрийн тогтвортой байдлыг хангах, эрүүл мэнд, боловсролын салбар дахь төрийн үйлчилгээ, мөн дэд бүтэц, хөрөнгө оруулалт хийх зэрэг чухал үүрэгтэйгээс гадна орлогын тэгш хуваарилалт нь мөн нөлөөлж байдаг юм.

2022 оны Улсын Их Хурлын намрын чуулганаар батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээрт адил хөдөлмөрийн эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын жилийн татвар ногдуулах орлогын дүнд тодорхой хувь хэмжээгээр албан татвар ногдуулах өөрчлөлтийг тусгажээ.

Судалгаагаар хувь хүний орлогын албан татвар нь 2024 оны байдлаар нийт татварын орлогын 9.6 хуулийг бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

Уг татварын орлогын 78-аас 80 хуулийг цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого бүрдүүлж байна.

Олон улсын байгууллага. Үүнд Олон Улсын Валютын Сан, Дэлхийн банк, OECD-ээс хөгжиж буй орнуудад хүмүүн капитал, чадварыг нэмэгдүүлэх, бага, дунд орлоготой иргэдэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, татварын системийг

илүү прогрессив болгохыг зөвлөсөн байдгаас гадна ерөнхий бүх нийтэд хамаарах татварын бууралт хийх нь үр ашиггүй, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө ихтэй.

Мөн хувь хүний орлогын албан татварыг бүх түвшинд ижил болгож шатлалгүй хувь хэмжээтэй байх нь өндөр орлоготой хүмүүст илүү ашигтай байдаг талаар ч дурдсан байна.

Иргэний гаргасан өргөдлийн дагуу албан татварын хувь хэмжээг 1 хувь болгох тооцоололыг хийж үзэхэд сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого 2.6 их наядаар буурч, улсын төсөвт нөлөө үзүүлэхээр байна.

Иймд дээр дурдсан хууль тогтоомж, олон улсын байгууллагын зөвлөмж, судалгаанд үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 05 дугаар сарын 05 дугаар дүгнэлтийн үндэслэлийн хэсгийн 2.3-д заасан хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд албан татвар төлөгчийн орлогод ногдуулах жилийн албан татварт орлогоос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлэхээр зохицуулсан байх боловч уг татварын хөнгөлөлт нь хүний наад захын хэрэгцээг хангахад шаардагдах орлогыг бүрдүүлэхэд хангалттай дэмжлэг болохуйц биш байх тул Үндсэн хуулийн оршил хэсэгт дурдсан хүмүүнлэг нийгмийн зарчимд нийцүүлэн хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгох шаардлагатайг дурдах нь зүйтэй гэснийг удирдлага болгон нийт өргөдөлд дурдсан асуудлыг Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон Татварын багц хуулийн төсөлд багтсан Хувь хүний орлогын газрын тухай хуулийн төсөлтэй хамтатган хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Танилцуулга хийсэн Х.Ганхүү гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулаад асууж тодруулах, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д заасан орлогод нь ногдох албан татварыг 1 хувь бууруулах тухай нийтийн ашиг сонирхлын асуудлыг хөндсөн иргэдийн санал, дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Хоёр дахь асуудалдаа орьё.

**Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Б.Жавхлан Сангийн сайд, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Р.Мягмаржав Татварын Ерөнхий газрын Татвар хураалт, удирдлага арга зүйн газрын дарга, Б.Буяннэмэх Татварын Ерөнхий газрын Татвар төлөгчдөд үйлчлэх газрын дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 292 дугаар захирамжаар 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ажлын хэсгээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар гаргасан танилцуулгыг Ц.Туваан гишүүн танилцуулна.

Ц.Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2025 оны 06

сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 06 сарын 27-ны өдрийн 292 дугаар захирамжаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваанаар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ш.Бямбасүрэн, Д.Ганбат, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, М.Нарантуяа-Нара, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Даваагийн Цогтбаатар, Б.Уянга, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг 3 удаа хуралдсан бөгөөд ажлын хэсгийн гишүүдээс “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбоотойгоор Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаан татсантай холбогдуулж, мөн Монгол Улсын 2025 оны улсын төсвийг баталсантай холбогдуулан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол бүрэн хэрэгжиж дуусаагүй.

Түүнчлэн Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгээс боловсруулж байгаа “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дээрх тогтоолын төслийн зохицуулалтууд тусгагдсан учраас төслийг хэлэлцүүлэх шаардлагагүй гэж үзэж, уг тогтоолын төслийг буцаах зарчмын зөрүүтэй санал, мөн “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн гадаад валютын нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлж, үр өгөөжөө өгөх Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх боломжтой.

Алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 сарын 07-ны өдрийн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай 46, Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай 47 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр, гадаад валютын нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлж үр өгөөжөө өгөх, Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх боломжтой алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг хангах үүднээс хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид

учирч буй хүндрэл, үүний дотор газар ашиглахтай холбоотой асуудлыг судлан, эрх зүйн орчныг сайжруулж, хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зохицуулалтыг тогтоолын төсөлд нэмж тусгах зарчмын зөрүүтэй саналуудыг боловсрууллаа.

Түүнчлэн бусад хууль тогтоомжийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын Та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ц.Туваан гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцээд санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд ирүүлснийг Та бүхэнд тараасан байгаа.

Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг тогтоол, хууль, зүйл бүрээр нь хэлэлцээд явъя.

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

1 дүгээр зүйлийг хэлэлцлээ. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу?

Зарчмын зөрүүтэй санал байгаа юм уу?

Б.Жавхлан гишүүний микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа.

Засгийн газар дээр бид ингэж ярилцсан юм. Нөгөө дагасан тогтоол дотор ийм заалт байгаа.

2026 оны төсвийг өргөн барих үедээ нөгөө их дээд сургуулиудын хувьсах зардлыг хасъя гэдэг. Тэр заалтыг нь сугалаад авмаар байна. Хасаад. Ийм зарчмын зөрүүтэй санал байгаа юм.

Тэгэхдээ би уг нь тогтоол нь бүхэлдээ ажлын хэсгээс татаж байгаа юм байна гэж ойлгосон. Тэгсэн чинь үгүй юм байна шүү дээ.

Ц.Даваасүрэн: Хөөе. Б.Жавхлан гишүүн ээ. Энэ чинь өөр асуудал хэлэлцээд байгаа юм. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хэлэлцээд байгаа байхгүй юу.

Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй санал алга байна.

Алга байна. /алх цохив/

Ингээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хоёр.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй. Зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу?

Н.Наранбаатар гишүүн санал гаргасан юм байна. Гишүүд ээ, анхааралтай хандаарай. Анхааралтай хандана шүү.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1/12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт “12.1.24.тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг орон нутгийн ерөнхий орлогын данснаас татан төвлөрүүлэх” гэснийг хасах гэсэн санал байна. Саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Эхлээд бэлтгэе. Бэлтгэл хангая.

Н.Наранбаатар гишүүн саналаа тайлбарлаж байя. Энэ хооронд манайхан бэлдээдэх. Санал хураалтдаа.

Н.Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе.

Энэ зарчмын зөрүүтэй саналыг гишүүдээс дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа. Яагаад гэхээр улсын төсөвт төвлөрүүлдэг хэдхэн аймаг байгаа. 9 аймаг байгаа байх. Сая хамгийн сүүлд Дундговь нэмэгдсэн юм байна лээ.

Тэгээд энэ аймгуудын данснаас нь шууд Сангийн яам орлогыг нь дээш нь татаж авах ийм заалт оруулж ирээд байгаа юм.

Зүй нь бол эхлээд энэ аймгийнхаа өөрийн тэр төсөвт байгууллагуудынхаа хэвийн үйл ажиллагааг хангах санхүүжилтийг нь өгөөд, тэгээд дараа нь улсын төсөвт төвлөрүүлэх орлогоо шилжүүлэх ёстой.

Гэтэл энэ өөрчлөлтөөр зүгээр шууд хүний данс руу нь ороод, тэгээд орлогыг нь шууд татаад авдаг нэг ийм л заалт орж ирээд байгаа юм.

Тэгэхээр энэ заалтыг дэмжээд өгөөч ээ гэж хүсэх байна.

Ц.Даваасүрэн: Энэ чинь тэгэхдээ юу юм байна шүү. Зөвхөн санал гаргасан хүн юм шиг байна шүү. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм. Н.Наранбаатар гишүүний яриад байгаа зовлонг ойлгож байна.

Тэгэхдээ хэрвээ хэдүүлээ энэ зарчмаасаа ухрах юм бол энэ чинь ганц нэг аймгийн асуудал биш энэ чинь төсвийн тогтолцооны асуудал шүү дээ. Төсөв дээрээ бид хуваарилж аваад буцаагаад төсвийн суурь зардлуудыг нь тавьж өгдөг ийм л зарчмаараа явж ирсэн. 34, 35 жил явж ирсэн. Хэдүүлээ үүнийг л тодруулж орсон заалт болохоос биш саяын таны ярьснаар хэрвээ ийм тогтолцооны өөрчлөлт хийх юм бол энэ чинь шал өөр юм болоод явна шүү. Тийм.

Ц.Даваасүрэн: Ингээд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд ээ. Гишүүд бэлдэж үү? Ж.Ганбаатар гишүүнийх болоогүй байх юм. Ж.Ганбаатар гишүүн байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

Энэ дэмжигдчихлээ шүү.

Энэ чинь аягүй том зарчим өөрчлөгдөж байгаа шүү дээ. Өөрчлөгдөнө. Одоо тооцоолол чинь хүртэл өөрчлөгдөөд явна шүү дээ. Үгүй тэгнэ шүү дээ. Энэ чинь нөгөө татан төвлөрүүлнэ гэж байсан юм нь төвлөрүүлэхгүй шахуу юм болж магадгүй шүү дээ.

Энэ нэлээн том өөрчлөлт шүү. Одоо тэгээд Х.Булгантуяа дарга хүртэл оролцож байгаа юм болохоор одоо тэгээд би юу хэлэх вэ.

Ингээд 25 гишүүн санал хураалтад оролцож, 17 гишүүн дэмжиж, 52.9.

Сая энэ хоёр хоёулаа тайлбарлана лээ шүү дээ. Тэгээд энэ чинь аягүй том өөрчлөлт орчхож байгаа байхгүй юу.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? 2 дугаар зүйл дээр бий юу?

Алга байна. /алх цохив/

Ингээд хуулийн төслийн 2 дугаар зүйлтийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Ажлын хэсгээс байгаа юм байна. Тийм ээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр төслийн 3 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Б.Баярбаатар, Ш.Бямбасүрэн, Д.Ганбат, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, Н.Нарантуяа-Нара, Д.Пүрэвдаваа, П.Ганзориг, Да.Цогтбаатар, Б.Уянга, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

3 дугаар зүйл чинь юу байгаа билээ? Тайлбар бий юу? Манайхан. Тайлбар алга уу? Тийм ээ. Санал хураалт явлаа шүү. Санал хураалтдаа бэлдье.

Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

17 гишүүн санал хураалтад оролцож, 10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

4 дүгээр зүйл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгээс гаргасан саналыг хураалгая.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан ажлын хэсэг. Тайлбар байгаа юм уу? Ц.Туваан гишүүн ээ.

Ц.Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Ажлын хэсэг дээр санал гарсан. Тэгээд мөн оруулсан Засгийн газрынхантай Сангийн яамтай зөвшилцсөн.

2026 оны төсвийн тухай хууль батлахтай холбогдуулан чиглэл өгөх асуудал нэгдүгээрт яригдаж байгаа.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын даргын 192 дугаар захирамжаар баталсан Х.Булгантуяа Их Хурлын дэд даргаар ахлуулсан ажлын хэсгийн боловсруулсан санал, дүгнэлттэй нэлээн олон заалтууд давхцаж байгаа.

Дээрээс нь өмнө нь гарсан чиглэл өгөх тогтоолууд тодорхой хэрэгжилт муутай байна гэсэн саналыг ажлын хэсгийн гишүүд хэлсэн учраас энэ чиглэл өгөх тухай тогтоолыг тэр чигт нь буцаая гэдэг саналыг төсөл өргөн барьсан Засгийн газарт хэлээд, зөвшилцөөд энэ саналыг бүтнээр нь буцааж байгаа ийм асуудал.

Ц.Даваасүрэн: Тогтоолын төслийг буцаая гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 17 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 70.6 хувиар санал дэмжигдсэн байна.

Гурав дахь хууль хэлэлцлээ.

“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Ж.Батжаргал гишүүн асуулт асууя. Та нэрээ өгөөрэй. Ж.Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл байгаа юм. Энэ тогтоолын төслүүд дээр одоо манай ажлын хэсэг ажиллаад тодорхой саналууд оруулж ирж байгаа юм байна. Тэр нь зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор яригдах юм байна гэж.

Тэгэхээр тэр нь улсын тусгай хамгаалалтад авсан газар, хилийн цэстэй холбоотой өөрчлөлт оруулах юмыг судлаад оруулж ир гэж яригдаж байгаа ийм чиглэл юм байна гэж ойлголоо. Мөн биз дээ.

Түүнээс гадна одоо ашиглагдаж байгаа стратегийн ордуудын чинь баяжмалын овоолгон дотор буюу шалам¹ дотор тодорхой хэмжээний алтны нөөц байна гэдэг юм тодорхой байгууллагуудын тайлан, дүгнэлтүүдээр гарч ирээд байгаа юм. Тэр нь магад ч үгүй Монгол Улсын татан төвлөрүүлдэг алтных нь хэмжээгээр тооцож үзвэл бараг 2 жилийнх нь нөөцтэй тэнцэх хэмжээний юм тэнд хаягдаад үлдээд байна гээд байгаа юм.

Тэгэхээр үүнийг тогтоолын төсөлд багтааж оруулах бололцоо байна уу? Одоо аж ахуйн нэгжийнх нь гэдэг юм уу, хуулийн этгээдийнх нь нэрийг заалгүйгээр ерөөсөө энэ ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байгаа үйл явцад дотор үүсэж байгаа тэр үүсмэл ордод дотор үлдсэн нөөцүүдийг ашиглах тухай заалт байж болох уу гэдэг асуулт байгаад байна.

Хоёр дахь зүйл. Энэ тогтоолын 2 дахь дэд заалт нь юм. 2.2 дээр нь гэсэн үг юм уу. Тийм байх. Тэр заалт дээр нэг асуудал гарч ирээд байгаа юм.

Албан ёсны зөвшөөрөлтэй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ямарваа нэгэн этгээд хууль бус байдлаар саад учруулж таарахгүй. Түүнд ногдох хариуцлага юмыг чангатгана гэдэг ийм үг байгаа юм. Энэ бол явж явж нарийндаа орон нутгийн иргэд, малчидтай хийж байгаа асуудал. Улаанбаатар хотын иргэдийн подъездных нь үүдэн дэх газрыг ухаад байвал тэр оршин суугчид ямархуу байх вэ? Ялгаа байхгүй асуудал байхгүй юу.

Тэгэхээр зэрэг үүнийг бас ингэж хуулиар нэг талд нь давамгайлж янз бүрийн асуудал үүсгэмгүй байна. Чиглэлээр.

¹ Намаг, шавар, лаг шавхай ихтэй газар.

Тэгэхээр үүнийг ер нь зөв, бас нэг хоорондоо ойлголцоод улс орныхоо хөгжлийн төлөө бас тодорхой ашигт малтмалуудаа ашиглаж болдог, тэр орон нутагт бас үр өгөөж юм нь хууль журмынхаа дагуу одоогийнхыг бодвол бас хөгжил юманд нь нэмэртэй байдлаар үлдэж болдог ийм зохицуулалт юмнуудыг ер нь юу гэж харж байна аа? Энэ дээр нэг тодорхой хариулт авъя.

Ц.Даваасүрэн: Ц.Туваан гишүүн хариулъя.

Ц.Туваан: Салбарын яамнаас бас нэмэлт тодруулга өгчхөөрэй.

Ж.Батжаргал гишүүн маш тодорхой гурван асуулт асуулаа. Тэрний эхнийх нь буюу тусгай хамгаалалттай газрын нутгийн хил заагтай холбоотой асуудал дээр Засгийн газраас төсвийн тодотгол батлахтай холбогдуулан дагаж орж ирж хууль, Их Хурлын тогтоолын төсөл дээр санал гаргах эрх нь, өргөн барих эрх нь Засгийн газарт юм билээ. Хуулиараа.

Тэгэхээр энэ тогтоолынхоо 5 дугаар зүйл заалт дээрээ үүнийгээ оруулж ир гэдэг байдлаар тусгасан явж байгаа.

Тэгэхээр таны нэгдүгээр асуулт бол яг энэ байдлаар хуулийнхаа дагуу тусгагдсан гэдгийг хэлье.

Хоёрдугаар асуудал дээр энэ алттай холбоотой, ялангуяа худалдааны дайн, эдийн засгийн хүндрэл, төсвийн орлого бүрдэлттэй, дээрээс нь валютын нөөц, төгрөгийн ханштай холбоотой асуудлууд дээр “Алт-3” аян голлож чиглэж явж байгаа.

Тэгэхээр энэ дээр ерөөсөө гол зорилго нь үүнийг эрчимжүүлж олборлолт, тушаалт, янз бүрийн асуудлуудыг нэмэгдүүлж эрчимжүүлэх гэдэг концепц явж байгаа. Өмнөх Засгийн газрын үед бас “Алт-3” аяны Засгийн газрын тогтоол нь гарсан.

Энэ дээр Ж.Батжаргал гишүүн бас тодорхой санал тавьсан. Тэр нь юу гэхээр Оюу Толгойн ордын аудитын дүгнэлт дээр экспортод гарсан алтны хэмжээ. Мөн уулын ажлын төлөвлөгөөнд батлагдсан хэмжээ хоёрын хооронд зөрүү гараад. Энэ зөрүү нь тэр **APL**² буюу тэр бүрэн металаа авч чадаагүй хэсэгт байгаа овоолгыг ашиглах гэдэг маш тодорхой зүйл, заалт ярьсан юм.

Тэгэхээр энэ асуудлыг нэлээн нухацтай, ялангуяа “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Оюу Толгой” гээд компаниудтай бас ярилцаж тусад нь нэлээн нухацтай төсвийн тодотгол хэлцэгдэх богино хугацаанд биш ярилцъя гэдэг

² Assayed Precious Load - Шинжилгээгээр тогтоогдсон үнэт металл.

Actual Precious Load - Бодитоор агуулж буй үнэт металл агуулга/гарц.

байдлаар салбарын яамныхантай ярилцаад дахиж тусад нь энэ асуудлыг ярьж гэдэг байдлаар оруулж ирсэн.

Гурав дахь асуудал нь ерөөсөө уул уурхайн салбар, тэр дундаа хайгуулын лицензтэй холбоотой, ашиглалтын лицензтэй холбоотой орон нутагтаа учраа олох гэдэг энэ асуудлууд маш чухал байгаа юм.

Одоо яг бодит байдал дээр хайгуулын лиценз аваад л хүн орон нутагт нь хууль журмынхаа дагуу очиход л эхний асуудал орон нутгийн удирдлага болон иргэдээс эсэргүүцэлтэй тулгарч байгаа.

Тэгэхээр энэ асуудал нь нэлээн тодорхой тусгахаар Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг дээр нэлээн яригдаад хууль руугаа нэлээн оруулж ярьж байгаа учраас энэ асуудлыг хууль өргөн барих үед нь ярилцъя гэдэг байдлаар бид хэд ярилцсан гэдгийг хэлье.

Тэгээд бүрэн эрхийн хүрээнд Байнгын хорооны гишүүнийхээ хувиар зарчмын зөрүүтэй санал гаргаад явах эрх нь... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байна байна. Энд нэг санал. Ажлын хэсгийн санал байгаа юм байна.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын ““Алт-3” аяныг 2025 оны ... дугаар сарын ... өдрөөс эхлэн орон даяар зарлан хэрэгжүүлсүгэй” гэснийг “дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Найруулгын чанартай юм байна шүү дээ. Тийм ээ. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар санал дэмжигдсэн байна.

Энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулаад Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. 2 дахь заалтыг хасахаар нөгөө дараах арга хэмжээнүүд чинь байхгүй болно шүү дээ. Найруулга нь буруу байна шүү дээ. Дугаарыг л гэж хэлнэ шүү дээ. Тийм шүү. Тэрийг Ц.Туваан гишүүн микрофонд

хэлчих. Тэгэхгүй бол нөгөө дараах арга хэмжээнүүд чинь байхгүй болох байхгүй юу. 2 дугаар зүйлтэйгээ хамт.

Ц.Туваан: Тийм. Энэ дугаарлалттай холбоотой, хоёр заалтыг нэгтгэсэнтэй холбоотой сая найруулгаар 2 дахь заалтыг хасах биш, яг сая Байнгын хорооны даргын томьёолсноор оруулаад явуулчихъя.

Ц.Даваасүрэн: Би протоколд тэмдэглээд үлдээе.

Тэр 2 гээд “Алт-3” аяныг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарт даалгасугай. “Үүнд” гэснийг хасах.

Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар санал дэмжигдсэн байна.

Тэгэхээр дараах арга хэмжээнүүд нь 1 рүүгээ шилжээд явж байгаа гэж ойлгож болно.

Гурав дахь санал. Саяын тэр нөгөө “Алт-3” аяны холбогдуулан авах тогтоолын төслийн.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтад “эрх, үүргийн харилцааг тодорхой болгож,” гэсний дараа “төсөл хэрэгжиж байгаа суманд үр өгөөжийн дийлэнхийг үлдээж” гэж нэмэх, мөн дэд заалтын “эрх зүйн орчныг өөрчлөх” гэснийг “эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж өөрчилж, мөн дэд заалтын “арга хэмжээ шуурхай авах” гэснийг, 3 дахь дэд заалтын “арга хэмжээ авах” гэснийг тус тус хасах.

2 дахь заалт. Тийм ээ. Гишүүд ээ, сайн хараарай.

Энэ орж ирсэн санал дээр бид нэг их тэгээд л Их Хуралд өргөн мэдүүл гээд л байх хэрэг байна уу? Өөрсдөө өргөн мэдүүлнэ л биз дээ. Аан..?

Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

18 гишүүн санал хураалт явуулж, 8 гишүүн дэмжиж, 44.4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

4.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 4 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж нэмж, мөн заалтын “алтны” гэснийг, мөн дэд заалтын “батлуулах” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

18 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

Энэ уг нь Засгийн газар өөрөө оруулж ирээд л явна биз дээ. Их Хурал заавал өргөн мэдүүл гээд байх ямар хэрэг байгаа юм.

5.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтын “эргэлтэд оруулах” гэсний дараа “зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” 46, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 47 дугаар тогтоолын холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Ямар хэрэг байна аа? Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Асуулт асууж болно. Саналаа тайлбарлах юм уу? Да.Цогтбаатар гишүүн санал гаргасан юм уу?

Да.Цогтбаатар: Тусгай хамгаалалттай газар нутгийг Засгийн газрын тухай хуулиараа тусгай хамгаалалтад авах, газрыг авах, бүртгэх эсэх асуудал чинь Засгийн газрын өргөн мэдүүлснээр Их Хурал батлах болохоос биш Улсын Их Хурлын гишүүн нь санал гаргаад авах, шийдэх асуудал биш юм билээ.

Тэгээд тэрийг нь хурдан хийж оруулж ирээрэй гэдэг чиглэлийг нь л Засгийн газарт өгч байгаа.

Сая “Алт-3” аяны хүрээнд энэ чинь дутуу ороод ирж байгаа асуудлыг гүйцээе гэж санал гаргасан нь Засгийн газрын тухай хуультай зөрчилдсөн учраас санал дээрээ найруулга л хийж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Саяын ажлын хэсгийн гаргасан тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 50 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дэмжигдээгүй гэсэн үг. Тийм ээ.

6.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх.

“6/Тогтоолын төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтад заасан нөхцөлийг хангах үүднээс хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид учирч буй хүндрэл, үүний дотор газар ашиглахтай холбоотой асуудлыг судлан, эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

18 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж, 38.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

7.Тогтоолын төсөл доор дурдсан агуулгатай 3, 4 дэх заалт нэмэх.

“3.Энэ тогтоолын биелэлт хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай гэж байна.

4.Энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.”

Санал гарсан ажлын хэсэг. Энэ дэмжих юм байна шүү. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

18 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын шинж чанартай нэг санал хураалгая.

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөдөлгөхгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар найруулгын санал дэмжигдсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн. Саналаараа танилцуулах гишүүн байна уу? Ж.Баясгалан гишүүн.

**Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг/**

Гурав дахь асуудал. Одоо өнөөдрийн хамгийн гол асуудал эхэлж байна шүү.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийг би Та бүхэнд танилцуулъя.

Б.Жавхлан Сангийн сайд, С.Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Н.Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ц.Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Д.Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, И.Батхүү Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Д.Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн оролцож байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй сорилт, бэрхшээлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Эдийн засгийн сорилт, хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй.

Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэсэн бөгөөд дараах зарчмыг баримталлаа.

▷ **Нэгдүгээрт**, оновчтой бүтэцтэй, цомхон, чадварлаг төрийн албыг бий болгоё.

Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтийн хүрээнд Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, 20 минут хот Үндэсний хороодыг татан буулгаж, холбогдох чиг үүргийг шилжүүлсэн бөгөөд Хилийн боомтын захиргааг Сангийн сайдын багц буюу Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд буюу Эдийн засаг, хөгжлийн сайдын багц руу, 20 минутын хот хөгжлийн төвийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багц руу тус тус шилжүүллээ.

Тус арга хэмжээний хүрээнд 48 орон тоо, 8.4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардлыг хэмнэлээ.

Мөн салбарын хуулиар тусгайлан зохицуулаагүй чиг үүргийн давхардалтай хороо, зөвлөл, комисс болон тэдгээрийн ажлын албыг татан буулгах бодлогын хүрээнд:

- ▶ Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн Үндэсний хороо,
- ▶ Үндэсний баялгийн сан,
- ▶ Орон сууцжуулалтын Үндэсний хороо,
- ▶ Хархорум хотын бүтээн байгуулалтын Үндэсний хороо,
- ▶ Аж үйлдвэржилтийн Үндэсний хороо,
- ▶ “Алсын хараа-2050 салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо,
- ▶ Эрчим хүчний реформын уялдааг хангах Үндэсний хороо,
- ▶ “Шинэ хоршоо” хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо,
- ▶ Эдийн засгийн бодлогын зөвлөлийн ажлын алба,
- ▶ Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл,
- ▶ Сансрын бодлогын Үндэсний зөвлөлийг тус тус татан буулгаж,

40 орон тоо, 11.2 тэрбум төгрөгийг тус тус хэмнэхээр тооцлоо.

Төрийн албаны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, чиг үүргийн давхардлыг бууруулж, чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх зорилтын хүрээнд багш, эмчээс бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулахаар тооцож, 14.4 мянган орон тоо, цалин хөлсний зардал 261.0 тэрбум төгрөгийг хэмнэхээр тооцлоо.

▷ **Хоёрдугаарт**, Төрийн ажил, үйлчилгээг цахимд шилжүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, инновац бүрийг салбар бүрийн онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх замаар иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний чанарыг бууруулалгүй бүх шатны төрийн байгууллагуудын зардлыг нь хэмнэе.

Энэ хүрээнд бүх шатны төрийн байгууллагуудын зайлшгүй нэн тэргүүний шаардлагатайгаас бусад зардлыг хэмнэж, хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хэмнэлтийн горимоор үргэлжлүүлэх, харин хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр, арга хэмжээг бүрэн хэмнэхээр тооцлоо. Үүнд:

1.Засгийн газрын шийдвэрээр төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилийг дуустал нэмэгдүүлэхийг хориглосонтой холбоотойгоор төсөвт байгууллагуудын түлш, халаалтын тарифыг нэмэгдүүлэхээр тооцож 2025 оны төсөвт тусгасан байсан халаалтын зардлыг хэмнэлтээр тооцож 121.9 тэрбум төгрөгөөр.

2.Төрийн тусгай байгууллагуудаас бусад бүх шатын төсвийн байгууллагын тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хичээл үйлдвэрлэлийн зардлыг хэмнэхээр тооцож 28.9 тэрбум төгрөгөөр.

3.Төрийн өндөр дээд айлчлалын болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албанд томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэхээр тооцож, холбогдох зардлыг 4.5 тэрбум төгрөгөөр.

4.Бүх шатны төсвийн байгууллагын тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж, техникийн зардлыг тэвчиж, зардлыг 104.0 тэрбум төгрөгөөр.

5.Төсвөөс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасын зардлыг 76.8 тэрбум төгрөгөөр.

6.Байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшууллийг хэмнэж, зардлыг 30 тэрбум төгрөгөөр.

7.Бүх шатын төсвийн байгууллагуудын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хэмнэх хүрээнд 617.3 тэрбум төгрөгийг тус тус хэмнэхээр тооцож, холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Дээрх арга хэмжээний хүрээнд хэмнэлтийн тодотголоор төсвийн зардлыг 1 их наяд 508.4 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцооллоо.

Үүн дээр Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор худалдан авах ажиллагааг бүрэн дуусгах,

гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцох, зарцуулахгүй байх зохицуулалтын хүрээнд Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар батлагдсан төсвийн хэмнэлтэд тооцох тухай тогтоолд туссан 535.9 тэрбум төгрөгийг нэмж тооцвол 2 их наяд 44.2 тэрбум төгрөгөөр зарлага буурахаар байна.

Уг тогтоолын хүрээнд:

- ▶ Эрүүл мэндийн сайдын багцаас 69 тэрбум,
- ▶ Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайдаас 57 тэрбум,
- ▶ Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайдаас 36 тэрбум,
- ▶ Боловсролын сайдын багцаас 33 тэрбум,
- ▶ Зам тээврийн сайдаас 33 тэрбум,
- ▶ Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаас 19 тэрбум,
- ▶ Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцаас 17 тэрбум төгрөг,

- ▶ Цахим хөгжлийн сайдаас 12.4 тэрбум төгрөг,

Бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцаас нийтдээ 255 тэрбум төгрөг,

Нийт 535.9 тэрбум төгрөгийг төсвийг хэмнэлтэд тооцлоо.

Нөгөөтээгүүр Монгол Улсын олон улсад хүлээсэн үүрэг болон эрчим хүчний найдвартай байдлыг хангах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай дараах 3 зардлыг төсвийн тодотголд нэмж тусгасан болно. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын байнгын нарийн бичгийн дарга нарын газар хооронд 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан хэлэлцээрийн хүрээнд COP-17 дугаар бага хурлыг 2026 оны 8 дугаар сард Монгол Улсад зохион байгуулахтай холбогдуулан хурлын бэлтгэл ажилд шаардагдах хөрөнгө оруулалт.

2. Дулааны цахилгааны станц-3 төрийн өмчит хувьцаат компанийн өндөр даралтын турбин цехийн барилга байгууламжид гэнэтийн аваар осол гарч томоохон эрсдэл үүссэнтэй холбогдуулан гамшиг ослын хохирол, хор уршгийг бууруулах, өвлийн их ачаалал, дулаанжуулалтын тоноглолын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагын хүрээнд гарах зардал болон дулааны станцууд,

эрчим хүчний компаниудын найдвартай ажиллагааг хангах, эрчим хүчний шөнийн тарифын хөнгөлөлтийн хугацааг уртасгасантай холбоотой гарах зардал.

3.3 Зуны үер ус, намрын тариалалт болон өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбогдуулан урьдчилан тооцож, төлөвлөж тусгах боломжгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэх нөхцөл үүсэж болзошгүйг харгалзан үзэж, Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэн тусгалаа.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбумаар бууруулж, 30 их наяд 209 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856 тэрбум төгрөгт бууруулж, 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5 хувийн алдагдалтай болж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2005 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна.

С.Магнайсүрэн даргын микрофон. 5 номерын микрофоныг.

С.Магнайсүрэн: Монгол Улсын Их Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06

сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 2.9 тэрбум төгрөгөөр, зарлагыг 356.3 тэрбум төгрөгөөр тус тус бууруулахаар төлөвлөсөн байна.

Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарлаа хандуулахыг санал болгож байна. Үүнд:

1.Уул уурхайн салбарын орлого гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч тодорхой бус, эрсдэлтэй байгаа тул уул уурхайн бус орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хураалт үйлчилгээг сайжруулах.

2.Төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийгээгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлж болзошгүй.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудын орон тоонд зохицуулалт хийх боломж олгох асуудлыг судалж үзэх.

3.Төсвийн тодотголын хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан.

Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагуудад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэл байгааг анхаарч үзэх.

4.Төсвийн ерөнхийлөн захирагч нар нарын харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн дагуу ажлаас чөлөөлөгдсөний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар

байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарз шийдлийг олох.

Дээрх саналуудаас гадна төсөвт тодотгол хийх нөхцөл үүссэн тохиолдолд төрийн аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагааны үе шатны стандартын дагуу хянаж, дүгнэлт гаргахад цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байх тохиолдол гарч байгааг анхааралдаа авч, дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд хүргүүлэх зохистой хугацааг Төсвийн тухай хуульд тусгаж өгөх шаардлагатай байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: С.Магнайсүрэн даргад баярлалаа.

Хоёр танилцуулгатай холбогдуулаад Монгол Улсын Сангийн сайд, Ерөнхий аудитор хоёроос асуух асуулттай гишүүд байна уу?

Д.Батбаяр гишүүн асууя.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд сая яг энэ Байнгын хорооны хурлын өмнө бас Зарлагын хяналтын дэд хороо хуралдсан. Тэгээд энэ хурал дээр бас гишүүдийн хэлж байгаа санал, мөн урьдын хурлууд дээр гишүүдийн санал болгож байсан саналуудыг нэгтгээд дүгнэх юм бол энэ жижиг үнийн дүнтэй гүйлгээнүүд, төсвийн зарлагууд, жижиг зарлагууд дээр ер нь ямар хяналт байгаа вэ гэдэг дээр их эргэлзээтэй байгаад байгаа нь харагдаад байна.

Тэгэхээр энэ төрийн санд ер нь хэзээ аудит хийсэн бэ? Аудитын тайлан байна уу? Бас нэг ийм санал асуулт байна.

Ц.Даваасүрэн: Хэн хэн хариулах вэ? 5 уу? Аан. 6 хариулъя.

Ц.Наранчимэг: Гишүүний асуултад хариулъя. Манайх 2018 онд.

Ц.Даваасүрэн: Нэр, албан тушаалаа хэлээд хэлээд яахгүй бол. Протокол явж байгаа.

Ц.Наранчимэг: Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал Ц.Наранчимэг.

2018 онд Төрийн сангийн үйл ажиллагаа, үр дүн гэсэн гүйцэтгэлийн аудитыг хийсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Д.Батбаяр гишүүн тодруулъя.

Д.Батбаяр: Тэгэхээр 2018 гэдэг чинь одоо 7 жилийн өмнө хийсэн байх нь байна шүү дээ. Тийм ээ. Тэгээд жил болгон хийж байгаа.

Тэгэхээр үүнийг яадаг юм, өөрсдөө хийдэг юм уу, эсвэл захиалгаар Улсын Их Хурлын гишүүдийн ч юм уу, холбогдох Засгийн газрын журмаар захиалгаар хийдэг юм уу? Хэн нь хариулах вэ? 6 номерын микрофоныг өгье. Хариулъя.

Ц.Наранчимэг: Жил бүрийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг хийхдээ төрийн сангийн үйл ажиллагааг хамруулж үзэж байгаа.

Яг гүйцэтгэлийн аудитыг 2018 онд хийсэн. Хуулиараа Төсвийн байнгын хороо жил бүр төрийн аудитын байгууллагыг аудит хийх сэдвийг баталж өгдөг. Тэр сэдэвт батлагдсан тохиолдолд аудитыг хийдэг.

Ц.Даваасүрэн: Тийм. Д.Батбаяр гишүүн нөгөө жилийн юунд уг нь саналаа өгөөд явсан бол болох байсан шүү дээ. Бид батлаад явчихсан.

Д.Батбаяр гишүүний микрофон.

Д.Батбаяр: Сэдэв өгөх дээр бол яах вэ энэ жил 2 өөр сэдэв би өгсөн юм л даа.

Төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа, нийцлийг. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, гаднын зээл, тусламжаар хийгдсэн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн, нийцэл гээд 2 сэдэв өгсөн байгаа. 3 сэдэв болоогүй.

Тэгэхээр энэ жилийнх дээр нь яг энэ төрийн сангийн үйл ажиллагааны гүйцэтгэл гэдэг байдлаар нь өгчихье. Та хэд тэгээд эртхэн юугаа тавихдаа эртхэн төлөвлөчхөөрэй.

Ц.Даваасүрэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийг хэлэлцээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллын санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд ирүүлснийг Та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж ажилласан.

Ажлын хэсгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг ажилласан.

Ажлын хэсгийн танилцуулгыг Х.Ганхуяг гишүүн танилцуулъя. Х.Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын дарга 2025 оны 291 дүгээр захирамжаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэслэлийг баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан.

Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг ахлан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан нар ажиллалаа.

Ажлын хэсэг 2025 оны 06 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал болон гадаад зээл, тусламж хариу үзсэн дэд ажлын хэсгүүдэд хуваагдан ажилласан.

Ажлын хэсэг дэд ажлын хэсгүүдийнхээ санал, дүгнэлтийг хэлэлцэн 2025 оны 06 дугаар сарын 29, 30, 07 сарын 01-ний өдрүүдэд тус тус хуралдаж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

1.Урсгал зардлын талаар:

1.1.2025 онд төсвийн жилд хэмнэж болох зарим томилгоог хойшлуулахтай холбоотой дараах зардлыг тодорхой хувиар бууруулах

боломжтой байна гэж үзсэн бөгөөд урсгал зардлыг 51 тэрбум 777 сая төгрөгөөр буюу доор дурдсан хэмжээгээр бууруулахаар байна. Үүнд:

➤ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг 2.6 тэрбумаар,

➤ Дэд сайдын томилгоо хойшлохтой холбоотой урсгал зардлыг 2.1 тэрбумаар,

➤ Сангийн сайдын төсвийн багц дахь Засгийн газрын нөөц сангийн зардлыг 16 тэрбумаар,

➤ Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зарлагын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.3 хувиар буюу 30 тэрбум төгрөгөөр бууруулах,

1.2.2025 оны тодотголын төслөөр төсөв нь буурсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулахад шаардагдах зарим санхүүжилт болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.

Түүнчлэн Засгийн газраас хуулийн төслийг татаж авсантай холбоотойгоор зарим зардлыг доор дурдсан хэмжээгээр буюу нийт 20 тэрбум 777 сая төгрөг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

➤ Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас татаж авсантай холбогдуулан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 1.1 тэрбумаар,

➤ Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын урсгал зардлыг 1 тэрбумаар,

➤ Гэр бүл, хүүхдийн хэрэг маргааны шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүхийг шинээр байгуулах бэлтгэл ажлыг хангахад шаардагдах зардалд зориулж Шүүхийн ерөнхий зөвлөлийн урсгал зардлыг 12.5 тэрбумаар,

➤ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд Монгол талын хариуцах зардал буюу Монгол, Германы хамтарсан Технологийн дээд сургуулийн татаасыг 517 сая төгрөгөөр,

➤ Монгол, Япон эмнэлгийн татаасыг 1.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, Боловсролын сайдын урсгал зардал нийт 2.1 тэрбум төгрөгийг нэмж тусгах.

➤ Мөнгө угаах, хөрөнгө буцаах үндэслэн дамнасан болон авлига албан тушаалын хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой болон прокурорын байгууллагын гэрээгээр хүлээсэн зарим зардлыг санхүүжүүлэхэд зориулж Улсын ерөнхий прокурорын урсгал зардлыг 1.3 тэрбум төгрөгөөр,

➤ “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг нэмэгдүүлнэ гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн зардлыг 458 сая төгрөгөөр,

➤ 2025 оноос хос бичигт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны урсгал зардлыг 936 сая төгрөгөөр,

➤ Говийн бүс нутгийг усжуулах, усан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд хийгдэх судалгаа, шинжилгээний зардлыг 230 сая төгрөгөөр,

➤ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн үйл ажиллагааны урсгал зардалд зориулж Улсын дээд шүүхийн урсгал зардлыг 1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

2.Хөрөнгийн зардлын талаар:

2.1.2025 оны тодотголын төслөөр төсөв нь буурсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээг нэвтрүүлэх, үйл ажиллагааг тасралтгүй явуулах, боловсролын байгууллагыг хүүхдэд ээлтэй, хөгжлийн бэрхшээл болон жендэрийн ялгаваргүйгээр орчин бий болгож чиглүүлэх.

Мөн дээр дурдсанчлан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардагдах зарим санхүүжилтийг доор дурдсан хэмжээгээр буюу нийт 31 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж үзлээ. Үүнд:

➤ Төслийн 2 дугаар хавсралтын 20.3.2-т тусгагдсан “эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 19 тэрбумаар нэмэгдүүлэх,

➤ Төслийн 2 дугаар хавсралтын 12.1.3.2-т тусгагдсан “боловсролын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 7.4 тэрбумаар нэмэгдүүлэх,

➤ Төслийн 2 дугаар хавсралтын 11.1.1-д тусгагдсан “гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах. Баруун бүс” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 4.6 тэрбум тус тус нэмэгдүүлэх.

Ажлын хэсгээс гаргасан дээрх саналууд нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх зарчимд нийцсэн болно.

Мөн 2025 оны төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй боловч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх нэг саналыг ажлын хэсгийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Дээрх саналуудтай холбоотой зарчмын зөрүүтэй саналын томъёолол Та бүхэнд хүргүүлсэн.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгийн санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёолол хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Х.Ганхуяг гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Одоо бусад Байнгын хорооноос ирүүлсэн саналыг дараа нь явуулна.

Эхлээд ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулна. Тэгээд тэрний бүр төгсгөлд нь гишүүдээс гаргасан санал хураалт гэсэн ийм 3 санал байгаа. Асуулт дээр нь л яах юм байна. Түүнээс биш асуулт, хариулт байхгүй юм байна шүү.

Ингээд дэгийн тухай хуулийн дагуу ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж эхэлье.

Гишүүд санал хураалтад бэлдэх үү?

Ажлын хэсгийн санал.

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн зардал хооронд зохицуулалт хийх санал.

Санал хураалтад бэлдсэн учраас би Та бүхэнд зарчмын зөрүүтэй саналын таниулыг уншиж танилцуулъя.

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн зардал хооронд зохицуулалт хийх санал.

1.1.Зардал бууруулах санал:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчдын мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг 2.6 тэрбум төгрөгөөр;

-Дэд сайдын томилгоог хойшлуулахтай холбоотойгоор урсгал зардлыг 2,189.7 сая төгрөгөөр;

-Сангийн сайдын төсвийн багц дахь Засгийн газрын нөөц сангийн зардлыг 16,336.9 сая төгрөгөөр;

-Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зарлагын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.3 хувиар буюу 30,649.0 сая төгрөгөөр тус тус бууруулан, эдгээр эх үүсвэрээс дараах арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх. Үүнд:

1.2.Зардал нэмэгдүүлэх санал:

-Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас татаж авсантай холбогдуулан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 1,144.0 сая төгрөгөөр;

-Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр;

-Гэр бүл, хүүхдийн хэрэг маргааныг шийдвэрлэх анхан болон давж заалдах шатын шүүхийг шинээр байгуулах бэлтгэл ажлыг хангах шаардагдах зардалд зориулж Шүүхийн ерөнхий зөвлөлийн урсгал зардлыг 12,581.5 сая төгрөгөөр;

-Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд Монголын талын хариуцах зардал буюу Монгол-Германы хамтарсан Технологийн дээд сургуулийн татаасыг 517.5 сая төгрөгөөр, Монгол-Япон эмнэлгийн татаасыг 1,600.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн Боловсролын сайдын урсгал зардалд нийт 2,117.5 сая төгрөгийг нэмж тусгах;

-Мөнгө угаах, хөрөнгө буцаах, үндэстэн дамнасан болон авлига албан тушаалын хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой болон прокурорын байгууллагын гэрээгээр хүлээсэн зарим зардлыг санхүүжүүлэхэд зориулж Улсын ерөнхий прокурорын урсгал зардлыг 1,307.5 сая төгрөгөөр;

-“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Дотоодын их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг нэмэгдүүлнэ” гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн урсгал зардлыг 458.0 сая төгрөгөөр;

-2025 оноос хос бичигт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны урсгал зардлыг 936.7 сая төгрөгөөр;

-Говийн бүс нутгийг усжуулах, усан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд хийгдэх судалгаа, шинжилгээний зардлыг 230.0 сая төгрөгөөр;

-Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн үйл ажиллагааны урсгал зардалд зориулж Улсын дээд шүүхийн урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

1.3.Хөрөнгийн зардал нэмэгдүүлэх санал:

-Төслийн 2 дугаар хавсралтын 20.3.2-т туссан “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 19,000.0 сая төгрөгөөр;

-Төслийн 2 дугаар хавсралтын XII.1.3.2-т тусгагдсан “Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг 7,400.0 сая төгрөгөөр;

-Төслийн 2 дугаар хавсралтын XI.1.1-д тусгагдсан “Гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах /Баруун бүс/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 4,600.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Энэ санал дээр тайлбар бий юу? Б.Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Баярлалаа. Энд нэг ийм юм байгаа юм.

Тэр дэд сайдын томилгоог хойшлуулахтай холбоотойгоор урсгал зардлыг 2.1 тэрбум гээд. Энэ одоо Засгийн газрын хууль дээр дэд сайд нь нээлттэй байж л байгаа. Тийм.

Тэгэхээр тэр томилгоог хойшлуулна, наашлуулна гэдэг тийм шийдвэр Засгийн газар дээр ер нь гараагүй.

Тэгээд яг дэд сайдад зориулсан тийм эдийн засгийн ангилал бүхий зардал гэдэг юм төсвийн хууль дээр байдаггүй байхгүй юу.

Тэгэхээр байхгүй зардлыг дүн тавиад хасахаар болж байна уу, үгүй юу. Үүнийг нэг эргэж хараач ээ гэж байгаа юм.

Хоёрдугаарт, Засгийн газрын нөөцийг 50 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байгаа юм. 3-хан зүйл нэмэгдүүлж байгаа.

- ТЭЦ-3,
- Засгийн газрын нөөц,
- СОР-27.

Тэгэхээр миний хүсэлт. Энэ нөөцөө одоо намар юу ч болоо билээ, өвөл юу ч болоо билээ. Үүнийг 16-гаар нь хасалгүй 50-иар нь, хуучнаар нь үлдээгээд. Харин тэр 0.3 хувиар гэж байгаа 30 тэрбумыгаа 46 болгоод 0.3 хувь биш, 0.4 болгоод өгөөч ээ гэсэн ийм хүсэлт байна.

Дээрээс нь тэр зардал буцаад нэмж байгаа юмнууд дотор тэр эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж 19, боловсролын салбарынх 7 гэж байгаа юм.

Эдгээрүүд маань төрийн хэмнэлтийн хуулиар бас нэлээн энэ чинь хариуцлагажуулаад ингээд хасагдсан юмыг хэдүүлээ буцаагаад тавиад байх юм бол хойтон энэ хоёр салбарын улсууд маань өө эд нар ингээд буцаагаад л тавиад өгдөг юм гээд л. Тэгээд л 05 сарын 31-ндээ шахагдахгүй, тэгээд л хариуцлагагүй байдал маань буцаад сунжрах ийм л эрсдэл үүсэх вий л гэж би хэлэх гэсэн юм.

Тийм учраас тэр нөөцийг буцаагаад 50-иар нь тавиад, тэр 0.3 гэдэг хувийг 0.4 болгоод сайд нараасаа жигд хасаад 46 болгоод өгөөч ээ гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал байна.

Ц.Даваасүрэн: Зарчмын зөрүүтэй санал байж болохгүй. Тайлбартай.

Х.Ганхуяг гишүүн тайлбар өгье.

Х.Ганхуяг: Ажлын дэд хэсэг дээр энэ урсгал зардалтай холбоотойгоор ажилласан байдаг. Манай 9 гишүүн ажлын дэд хэсэгт орж ажилласан.

Энэ дэд сайдын томилгоотой холбоотой асуудал бол одоо энэ 16 яамны үндсэн цалин 3.5 сая, нэмэх нь 30 хувь. Энэ дээш гээд. Туслах гээд хүнийх нь тоогоор нь бодоод энэ юуг гаргасан юм билээ.

Тийм учраас үүнийг энэ ондоо. Одоо 5-хан сар үлдсэн юм чинь энэ ондоо хойшлуулвал яасан юм бэ гэдэг байдлаар гаргасан гэсэн үг. Одоо бид чинь үндсэндээ 12 мянган төрийн албан хаагчийг сул орон тоо байсныг нь хаагаад, нэмээд одоо 6 мянга гаруй төрийн албан хаагч халагдаж байгаа, цомхотголд орж байгаа.

Тийм учраас одоо бид нарын хувьд ёс зүйн талаа бодсон ч гэсэн, хэмнэлтээ бодсон ч гэсэн энэ асуудлыг хойшлуулвал яасан юм гэдэг санал гарсан байгаа.

Тэгэхдээ үүнийг гишүүд минь Та нар өөрсдөө л санал хураалтаар шийдээрэй.

Хоёрдугаар асуудал бол Сангийн сайдын Засгийн газрын нөөц сангийн зардлыг 16 тэрбумаар бууруулах болсон шалтгаан юу вэ гэхээр 2024 онд тухайлбал 128 тэрбум байсан. Тэгээд энэ нь энэ жил 180 тэрбум болж нэмэгдэж байгаа.

Ковидын үеийн нэлээн хүнд байх үед дунджаар 80-аас 100 тэрбум төгрөг байсан юм билээ. Тэгээд энэ дээр манай ажлын дэд хэсгээс гарсан санал хураагдаад дэмжигдээд явсан байгаа.

Гуравтдугаарт, энэ боловсрол болон эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжтэй холбоотойгоор бид яах вэ, одоо тэр сайд нь буруутай байна уу, Төрийн нарийн нь буруутай байна уу. Хоорондоо энэ чинь сайд нар нь солигдоод явдаг. Яах вэ, хариуцлагын асуудлыг Засгийн газрын хэмжээнд Та бүхэн өөрсдөө тэрийгээ тооцох ёстой байх.

Гэхдээ үүний үр дүнд Монголын ард түмэн, Монголын хүүхдүүд хохирч болохгүй юм. Одоо Эх, нялхсын эрүүл мэндийн төв дээр одоо жишээлбэл MRI нь эвдэрсэн байж байна. III дугаар эмнэлэг дээр шаардлагатай мэс засал, хагалгаагаа хийж чадахгүй байж байна. Баян-Өлгий аймаг шинэ эмнэлэг баригдаад тоног төхөөрөмжгүй байж байна.

Тийм учраас энэ он дуустал нэн шаардлагатай байгаа эрүүл мэндийн тоног төхөөрөмж.

Боловсролын салбар дээр үндсэндээ 30-аас 40 сургууль ашиглалтад энэ жил орж байгаа юм байна.

Тэгээд тэр нь ерөөсөө шинэ ширээ сандал байхгүй. Ширээ, сандал байхгүй.

Тэгэхээр чинь бид 09 сарын 01-нээс өмнө ширээ сандлыг нь авч өгч байж тэр сургуулиуд ашиглалтад оруулахгүй бол бид энд ингээд гоё сайхан юм яриад байдаг. Гэхдээ бид чинь үндсэндээ Үндсэн хуулиар хүлээсэн үүрэг, энэ боловсролыг олгох ёстой үүрэгтэй хүмүүс.

Тийм учраас шаардлагатай тоног төхөөрөмж дээр нь гишүүд маань дэмжиж өгөөрэй гэж санал хэлсэн юм. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ингээд дэгийн тухай хуулийн 71.8-д зарчмын зөрүүтэй саналыг хураахын өмнө Засгийн газрын тайлбарыг сонсож болно гэсний дагуу Б.Жавхлан сайд тайлбар хийгээд байгаа шүү.

Ингээд ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

18 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр. 2025 оны төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдүүлэх санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын XXVII.1.9-д тусгагдсан “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/ хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 36,134.9 сая

төгрөг, санхүүжих дүн 18,184.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Тайлбар хийх юм уу? Б.Жавхлан сайд

Б.Жавхлан сайд зөвхөн с юу яачихсан юм байна шүү дээ. Сангийн сайд, ажлын хэсэг тайлбарлахаар дэгийн хуультай юм байна шүү дээ.

Б.Жавхлан сайд тайлбараа хэлье.

Б.Жавхлан: Ховд ч байна уу, хаана ч байна уу төсөвт өртгийг ингэж нэмж болохгүй шүү дээ.

Одоо наадах чинь энэ удаа ингээд яах вэ төсөвт өртгийг нэмэгдүүлж байна гээд нэг зальдаж байгаа юм. Тэгээд наадах чинь дараа оных дээр наадах чинь яг үүгээрээ санхүүжилт нь нэмэгдэж орж ирнэ.

Энэ ёстой болохгүй шүү. Хаана ч байсан гэсэн, ямар ч төслийн төсөвт өртгийг тодотголоор ингэж болохгүй ээ.

Ц.Даваасүрэн: Энэ ажлын хэсгээс гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 50 хувиар санал дэмжигдсэнгүй.

Хоёр.Бусад Байнгын хорооноос гаргасан саналууд.

1.Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.3.1.1 дэх дэд заалтын “Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдах хүн” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин “100,000” гэснийг “15,000” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн санал.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

18 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 61.1 хувийн санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.3.2 дахь заалтад тусгагдсан “Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг сайжирна.” гэсэн хөтөлбөрийг бүхэлд нь хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн санал.

Ч.Ундрам гишүүн тайлбарлая.

Ч.Ундрам: Дэлхийн эдийн засгийн форумаас аялал жуулчлалын индексийг 2 жилд нэг удаа гаргадаг юм билээ.

Тэгээд энэ жил тийм индекс гаргадаг жил нь биш. Ирэх жилийн.

Тэгэхээр энэ жил үүнийг оруулахаар нөгөө индекс нь гарч ирэхгүй учраас энэ заалтыг бүхэлд нь хасаад, ирэх жилийнхээ зорилтот түвшинд бид оруулж ирэх юм.

Тийм учраас гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Мөнгөн дүн байхгүй. Зүгээр л индекс.

Ц.Даваасүрэн: Ч.Ундрам гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 77.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.4.1.1 дэх дэд заалтын “Зорилтот бүлгийн залуучуудын нийгмийн оролцоо, үйлчилгээнд хамрагдлыг нэмэгдүүлнэ.” гэсэн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин “46 хувь” гэснийг “30 хувь” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн санал.

Тайлбар л хийж болно. Санал гаргасан гишүүн тайлбарлаж болох юм байна. Ч.Ундрам гишүүн тайлбарлая.

Ч.Ундрам: Та бүхэн мэдэж байгаа манай яам бас залуучуудын асуудал хариуцдаг.

Тэгээд төсөв дээр залуучуудад зориулсан бүх мөнгийг хасаад тэглэсэн байгаа. Тэгээд бид одоо төсөвгүйгээр залуучууддаа сургалт явуулах асуудал байгаа юм.

Тийм учраас төсөв мөнгөгүйгээр ажлаа хийнэ. Гэхдээ энэ зорилтот түвшин буюу хавсралт 1 дээр байгаа ямар нэгэн мөнгөн дүнгүй энэ зорилтот түвшнийг бид одоо яг бодит өөрсдийнхөө хийж чадах хэмжээнд болгож бууруулж байгаа юм.

Тийм учраас гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Ц.Даваасүрэн: Ч.Ундрам гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 77.8 хувиар санал дэмжигдлээ.

4.Боловсролын сайдын төсвийн багцын урсгал зардлын Бараа, үйлчилгээний бусад зардлыг 5.8 тэрбум төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Төрийн өмчит их, дээд сургуульд олгох татаасыг нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Хэрлэн.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй санал.

Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Гишүүний саналаар хураах юм байна. Байж байгаарай. Гишүүний саналаар хураах юм байна шүү.

Боловсролын сайдын багцын урсгал зардлыг бараа, үйлчилгээний бусад зардлыг 5.8 төгрөгөөр бууруулаад боловсролын салбараас аваад. Ерөнхий боловсролын сургуулиудын гэсэн үг шүү дээ. Их дээд сургуулийн татаасыг нэмэгдүүлэх гэдэг санал байна.

Энэ саналыг дэмжье гэдгээр хураалгах юм байна. Тийм үү. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 3 гишүүн дэмжиж, 16.7 хувиар санал дэмжигдсэнгүй. Энэ санал дэмжигдээгүй.

Байнгын хорооны гишүүд бас зарчмын зөрүүтэй санал гаргах эрхтэй. Тэр эрхийн дагуу Байнгын хорооны гишүүдийн гаргасан саналыг хураалгана.

Энэ санал дээр харин одоо бас анхааралтай хандахгүй бол тооцоолол өөрчлөгдөх саналууд байна. Хурааж эхэлье.

Ж.Баясгалан гишүүний зохицуулалт хийх санал. Бууруулах санал нь

Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн тэнцлийн урсгал зардлын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэр, санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг урсгал зардлаас бусад урсгал зардлыг 0.045 хувиар буюу 4.5 тэрбум төгрөгөөр бууруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн урсгал зардлыг 2 тэрбум төгрөгөөр, Улсын дээд шүүхийн урсгал зардлыг 1.5 тэрбум төгрөгөөр, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын Биеийн тамир, спортын улсын хорооны дотоод зохиогдох олон улсын тэмцээний зардлыг 1 тэрбум төгрөгөөр, нийт 4.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Ж.Баясгалан.

Х.Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Би энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, энэ Дээд шүүхийн хүмүүст анхааруулад бас хэлмээр байна.

Та нарт бүх санхүүжилтийг чинь шийдээд өгсөн шүү дээ. Тэгээд бас гишүүдийг лоббид ингээд ийм санал оруулж ирээд байх юм. Нэг бол бид энэ ажлын хэсэг дээр сая хураалгасан саналаа буцаад татна шүү.

Ц.Даваасүрэн: Гишүүд ээ, ийм байна шүү. Хөөе. Б.Жавхлан сайд аа, Б.Жавхлан сайд л харин тайлбарлаж үг хэлж болох юм байна шүү дээ. Тэгэхгүй ажлын хэсэг болохгүй юм байна шүү. Тийм. Үгүй үгүй, саяын санал дээр зөвхөн тайлбар хийхээр бол өөрөө л чи тайлбар хийх юм байна. Байхгүй юм байна.

Ингээд Ж.Баясгалан гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн санал хураалтад оролцож, 4 гишүүн дэмжиж, 21.1 хувиар саяын санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Г.Ганбаатар гишүүний гаргасан санал байна. Зарчмын зөрүүтэй санал.

Ерөнхий сайдын багцын судалгааны зардлыг 2.9 тэрбум төгрөгөөр бууруулж, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцын усны газрын урсгал зардлыг 2.9 сая тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн санал байна.

Тайлбар алга байна. Санал гаргасан гишүүн тайлбар хийж болно.

Г.Ганбаатар гишүүнээс микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Энэ яах вэ, уг нь Байгаль орчны сайдын багцад гол, мөрний менежментийн хөтөлбөр гээд нэг хөтөлбөр байгаа юм.

Тэгээд энэхүү хөтөлбөрийн зардлаар хилийн усны асуудлууд, тэр 333 хөв цөөрмийн асуудал.

Тэгээд 2025 онд энэ хөтөлбөрт 3.2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн байсан. Тэгээд мөн эндээс бас нөгөө Эгийн голын усан цахилгаан станцыг явуулахын тулд энэ төсөл хөтөлбөрөөс 2 тэрбум төгрөгийг шилжүүлэх, говийн усны төслийг хэрэгжүүлэх төслийн багийг санхүүжүүлэх гээд.

Яах вэ, тэр 230 сая нь түрүүн ажлын хэсэг дээр дэмжигдсэн харагдсан. Тэр төслийн нэгжийн. Тэгээд үндсэндээ энэ төслийг ингээд явуулахгүй бол одоо Эгийн голын төслийн байдал зогсонги байдалд орох, цаашдаа говийн усны төсөл хойшлох тиймэрхүү хүндрэл учраад байгаа юм л даа.

Тэгээд гишүүд маань байгаль орчны чиглэлийн. Ялангуяа энэ говийг усжуулах асуудал, усан хангамж дутагдалтай бүс нутгийг усжуулах асуудал, дээрээс нь говийн бүсэд явагдаж байгаа томоохон боловсруулах үйлдвэрлэлүүдийг усаар хангах асуудал манай улсын зайлшгүй ойрын үед хийх ажлуудын нэг шүү.

Тэгэхгүй бол яваандаа боловсруулах үйлдвэрүүд чинь усан хангамжгүй болж байгаа юм гэдгийг л хэлж байгаа юм. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье.

Ц.Даваасүрэн: Түрүүний нөгөө баруун бүсийн юутай хамааралгүй юм байна. Тийм ээ. Бас яг ийм зардал байсан шүү дээ.

Г.Ганбаатар гишүүний зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Энэ санал бас хуулийн зөрчилтэй байна. Дэмжигдсэнгүй дээ.

19-өөс 8, 42.1 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

Чуулганаар ороход нь манай Тамгын газрынхан хянахгүй бол сая нөгөө Тусгай хяналтын дэд хороогоор орж байж манайх руу орох ёстой байсан юм байна шүү дээ. Энэ санал. Үүнийг анхаараарай.

Г.Ганбаатар гишүүн ээ, ингэе. Чуулганаар ороход үнэхээр Тусгай хяналтын дэд хороогоор орох ёстой дэгийн тухай хууль зөрчигдсөн байвал буцаад татахаас. Тийм. Зөрчилтэй санал болох гээд байна л даа. Тийм. Яах вэ, Тусгай хяналтын дэд хороон дээр гишүүн өөрөө гаргаж болох байсан байхгүй юу.

Б.Түвшин гишүүний гаргасан санал байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын урсгал зардал Ойжуулалтын хөтөлбөрийг 2 тэрбум 990 сая төгрөгөөр бууруулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын урсгал зардал, усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийг 2 тэрбум 990 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн ийм санал байна.

Ингээд энэ саналыг. Ойжуулалтыг усны нөөц болгоё гээд. Усны нөөц дээр ч их л мөнгө явж байна даа. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19-өөс 3 гишүүн дэмжиж, 15.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Г.Ганбаатар гишүүний гаргасан санал байна.

Боловсролын сайдын багцын Нийслэлийн боловсролын газар урсгал зардлыг 2.6 тэрбум төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын урсгал зардлыг 2.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн санал байна.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, 21.1 хувиар дэмжигдсэнгүй.

Г.Ганбаатар гишүүний гаргасан санал.

Засгийн газрын нөөц сангийн зардлыг 84.6 сая төгрөгөөр бууруулж, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг 84.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Г.Ганбаатар гишүүн болох юм байна. Санал гаргасан гишүүн нь тайлбар хийж болох юм байна. Тэгээд Сангийн сайд тайлбар. Ийм хоёрхон хүн л хийж болох юм байна.

Г.Ганбаатар гишүүний микрофоныг өгье. Төсвийн байнгын хорооны гишүүн гаргах дэгтэй юм байна л даа.

Г.Ганбаатар: Өнөө өглөө бас энэ зарчмын зөрүүтэй саналууд 3, 4.

Төсвийн байнгын хорооны гишүүний хувьд бас санал гаргах эрхтэй. Тэр хүрээндээ оруулж ирж байгаа. Тэгээд манай Б.Пүрэвдорж гишүүн сая хэллээ дээ.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор.

Сангийн сайд тайлбар хэлж болно. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 42.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Г.Ганбаатар гишүүний гаргасан санал байна. Энэ чинь бас Ерөнхий сайдын багцаас юм байна шүү дээ.

Сангийн сайд энэ дээр нэг тайлбар хийгээч. Ерөнхий сайдын урсгал багцаас бууруулах санал байгаа юм. Тэгээд энэ Тусгай хяналтын дэд хороогоор явахаар байгаад байгаа билүү. Эрүүл мэндийн сайдын багц руу шилжүүлж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ нөгөө Тусгай хяналтын дэд хороогоор орох болчихоод байгаа юм биш үү. Аан..? Сангийн сайдад тайлбар өгөх үү.

Энэ чинь урсгал зардлыг хөрөнгийн зардал руу шилжүүлэх. Бүр хурааж болохгүй. Төсвийн хуультай харьцуулах заалт байна шүү дээ. Дэмжигдээгүй байх. Тийм байна. Төсвийн хуулиар урсгал зардлыг хөрөнгө оруулалтад зарцуулж болохгүй.

Юу ч гэсэн тэгээд одоо хэдүүлээ Г.Ганбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж, 36.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Да.Цогтбаатар гишүүний гаргасан санал байна.

Засгийн газрын нөөц хөрөнгөөс 1 тэрбум. Мөнгөн дүнгээ та бичээгүй юм байна. Харин тэгэхдээ сая төгрөг гэдгээ бичээгүй юм байна шүү дээ.

1,781.1 сая төгрөг мөн үү? Би мянга гээд хураалгах гээд байна шүү. 1700 төгрөг гээд.

Энэ нөгөө хөрөнгө оруулалтын 16.1.12 уу? Тэрийг хэлэх ёстой.

Хөрөнгө оруулалтын хавсралтын 16.1.12-т “гэр хорооллын шугам сүлжээ, Өвөрхангай, Арвайхээр сум гэсэн арга хэмжээний төсөвт өртөг энэ жилийн санхүүжилтийн хоёуланг нь юм уу? Аан? Зөвхөн санхүүжих дүнг нь юм уу? Энэ жил санхүүжих дүнг нь юм уу, төсөвт өртөг нь орж байгаа юм уу? Аль аль нь нэмэгдэх юм уу? Үгүй үгүй. Та энэ жилийн санхүүжих дүнг нь нэмэгдүүлнэ гэж байгаа юм уу, аль эсвэл төсөвт өртгийг нь нэмэгдүүлнэ гэж байгаа юм уу. Аль нь юм?

Энэ жилийн санхүүжих дүнг 1,781.1 сая төгрөгөөр нэмэгдүүлье гэсэн санал байна.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар.

Саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж, 36.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Х.Булгантуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн тэнцлийн урсгал зарлагын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.01 хувиар буюу 1 тэрбум төгрөгөөр бууруулан Соёл, шинжлэх ухаан, аялал жуулчлалын сайдын багцын Биеийн тамирын сургалтын улсын хорооны дотоод зохиогдох олон улсын тэмцээний зардал 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн ийм санал байна.

Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн санал хураалтад оролцож, 10 гишүүн дэмжиж, 52.6 хувиар санал дэмжигдлээ.

Р.Батболд гишүүний гаргасан санал байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих татаас, урамшуулл”-ыг 15,000.0 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад байгаа “Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн даатгалын сан”-гийн төсвийг 15,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн санал байна.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Тайлбар хэлье гэнэ. Үүнийг хүчингүй болгочихъё. Энэ санал хүчингүй.

Р.Батболд гишүүн өөрөө тайлбараа хийе.

Р.Батболд: Гишүүд ээ. Нэг ийм юм байгаа юм шүү. Наад хөдөө аж ахуй, хоршоог дэмжих юу чинь уг нь 45 тэрбум байсныг нь 5 тэрбум болгоод байгаа байхгүй юу. Хасаад. 40-ийг нь хасчхаад байгаа юм.

Тэгээд яах вэ, ер нь наадах чинь Хөдөө аж ахуйн яаман дундаа гүйж байгаа асуудал.

Дээрээс нь бусад санхүүжилт татаасны юунууд нь бүгдээрээ байгаад байгаа юм. Энэ дээр.

Тэгэхээр одоо бол зүгээр хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал гээд 160 тэрбум байгаад байгаа. Үүнээс нь 15-ыг нь аваад хоршооны тэр юу руу, Зээлийн батлан даалтын сан руу л өгчихье гэсэн юм байгаа юм. Үүнийг нэг дэмжээд өгчхөөч.

Үгүй ээ, тэд нар нь тус тусдаа байгаа юм. Энэ чинь зөвхөн хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих гээд байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Яриад байгаа нөгөө хоршоолыг дэмжих зээлийн асуудал хүндрэх гээд байна гээд байгаа чинь байхгүй юу.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар санал дэмжигдлээ.

Үгүй ээ, Сангийн сайд маань тайлбараа хийхгүй бол ингээд л дэмжигдээд л байх байх шүү. Үгүй үгүй. Сангийн сайд өөрөө тайлбараа хэлэх ёстой шүү дээ.

Г.Ганбаатар гишүүний санал байна.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцыг хөрөнгийн зардлыг 1 тэрбум төгрөгөөр бууруулаад.

Гишүүд анхаараарай. Татаж байгаа юм уу? Та микрофондоо хэлчих.

Би уншъя. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багц хөрөнгийн зардлыг 1 тэрбум төгрөгөөр бууруулаад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд буюу Эдийн засаг, хөгжлийн сайдын багцын Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн урсгал зардлыг 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Г.Ганбаатар. Г.Ганбаатар гишүүн тайлбар хийе.

Г.Ганбаатар: Би энэ саналаа татаж байгаа юм.

Ер нь яах вэ, Төсвийн байнгын хорооны гишүүн санал гаргах эрхтэй гэдэг хүрээндээ бас хэд хэдэн зарчмын зөрүүтэй санал гаргасан. Гэхдээ цаг хугацаа нь дэндүү тулаад, бас оруулж ирж байгаа асуудлууд маань. Угаасаа бусад гишүүд л оруулж ирж байгаа шүү дээ. Бид нараар дамжуулаад. Тийм ээ. Тэр нь аль багцаас тэр зохицуулалт хийх эх үүсвэрээ бас хуулийн хүрээнд нийцүүлээгүй асуудлууд байгаа юм байна.

Тийм учраас татаж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Энэ саналаа Г.Ганбаатар гишүүн татаж авлаа.

Ж.Баясгалан гишүүний гаргасан санал байна.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцыг 2,976.0 сая төгрөгөөр бууруулаад Төсвийн тухай хуулийн 4.2.3 Шинжлэх ухааны хүрээлэнгийн Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмжийг 2,976.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн санал байна.

Ж.Баясгалан гишүүн энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүний санал хураалтад оролцож, 5 гишүүн дэмжиж, 26.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ер нь хуулийн зөрчилтэй байна. Энэ санал. Энэ гарын үсэгт байгаагаас нэр нь байхгүй байна. Хэн гэдэг гишүүн юм? Д.Батбаяр гишүүний гаргасан санал байна шүү.

Д.Батбаяр гишүүний гаргасан санал.

Сангийн сайдын багцын Засгийн газрын нөөц санг 50 тэрбум төгрөгөөр бууруулна.

Тэгээд зардал байхгүй юм байна шүү дээ. Зардлыг нь бичээгүй юм байна шүү дээ. Зүгээр хэмнээ гэж байгаа юм уу?

Сангийн сайдын багцын Засгийн газрын нөөц хөрөнгийг 50 тэрбум төгрөгөөр бууруулъя гэсэн санал байна.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 10.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Д.Батбаяр гишүүний бас гаргасан санал байна. Зардал бууруулах санал.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардал Эдийн засгийн хөгжлийн яамны гадаад албан томилолтын зардлыг 1,212.2 сая төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн санал хураалтад оролцож, 2 гишүүн дэмжиж, уг санал 10.5 хувиар дэмжигдсэнгүй.

Г.Ганбаатар гишүүний санал байна.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Эрчим хүчний реформын үндэсний хорооны 400 сая төгрөгийг хасаж, Гэр бүл, хөдөлмөр нийгэм хамгааллын сайд, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас төсвийг 400 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Г.Ганбаатар.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 36.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Гурав.Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах найруулгын санал.

1.Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх, засварыг хийх, мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацааны саналын томьёонд нийцүүлэн өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 19 гишүүн оролцсон 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийнхаа асуудалд оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг, бусад Байнгын хорооны гишүүд, Төсвийн байнгын хорооны гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Х.Ганхуяг гишүүн танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Одоо төсвийн хүрээний мэдэгдлийн анхны хэлэлцүүлгээ хийнэ. Гишүүд ээ.

**Дөрөв.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эхлүүлье.

Ажлын хэсэг Н.Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Н.Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Д.Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хороонд болон нэгдсэн хуралдаанд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн дарга Х.Ганхуяг гишүүн танилцуулна.

Х.Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 онд төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан.

Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг ахлан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан нар ажиллалаа.

Ажлын хэсэг 2025 оны 06 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд хуралдаж дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9-д зааснаар хууль санаачлагч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тусдаа үзэл баримтлалтайгаар өргөн мэдээлэх ёстой.

Гэвч 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хамтад нь өргөн мэдүүлсэн нь дээрх хуулийн заалтад нийцээгүй байна.

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д зааснаар дунд хугацаанд төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш 3 сарын дотор тухайн жилийн төсвийн төсөл, тодотголын төслийг өргөн мэдүүлэхийг хориглосон байдаг.

Иймээс 2026 оны төсвийн төслийг хуульд заасны дагуу 09 дүгээр сарын 01-ний өдөр дотор өргөн мэдүүлэх цаглаварт нийцүүлэн Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг татан авсан.

Иймээс Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,

2027-2028 онд төсвийн төсөөллийн тухай хууль дахь эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026, 2027 оны мэдэгдэл, төсөөллийн дагуу 2025, 2027 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийг өөрчлөх нь зүйтэй гэж үзлээ.

Холбогдох саналын томьёололыг Та бүхэнд хүргүүлсэн.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгийн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёололыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн дарга Х.Ганхуяг гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэх бөгөөд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Тэгээд зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Гишүүд хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асууж болно шүү.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй саналтай саналтай гишүүн байна уу? Байгаа юм уу? Ажлын хэсгийн санал байгаа юм байна. 1 дүгээр зүйл дээр. Тийм ээ. Гишүүд зарчмын зөрүүтэй санал байгаа учраас орж ирмээр байна.

Гишүүдээ оруулъя. Гишүүдээ тоолоорой.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/ 2026 онд “5.7” гэснийг “6.0” хувь гэж, 2027 онд “6.3” гэснийг “6.5” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “31,720.4” гэснийг “33,479.5” гэж, 2027 онд “33,761.0” гэснийг “35,628.6” гэж, Дотоод эдийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “30.9” гэснийг “31.7” гэж, 2027 онд “29.3” гэснийг “30.4” гэж, Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “32,839.8” гэснийг “33,479.5” гэж, 2027 онд “34,626.0” гэснийг “35,628.6” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь 2026 онд “32.0” гэснийг “31.7” гэж, 2027 онд “30.0” гэснийг “30.4” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ 2026 онд “-1,1” гэснийг “0” гэж, 2027 онд “-0.7” гэснийг “0” гэж, Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “29,666.4” гэснийг “30,314.5” гэж, 2027 онд “31,452.6” гэснийг “33,282.2” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “28.9” гэснийг “28.7” гэж, 2027 онд “27.3” гэснийг “28.4” гэж, Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/ 2026 онд “2,054.0” гэснийг “3,165.0” гэж, 2027 онд “2,308.4” гэснийг “2,346.4” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “2.0” гэснийг “3.0” гэж, Засгийн газрын өрийн нийт хэмжээ “тэрбум төгрөг/ 2026 онд “51,350.0” гэснийг “52,750.0” гэж, 2027 онд “51,939.0” тэрбум гэснийг “52,794.0” гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “2.6” гэснийг “2.5” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Тайлбар хийх юм уу?

Н.Учрал сайдын микрофоныг өгье. Тайлбар. Н.Учрал сайдын микрофон.

Н.Учрал: 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн хуульд ийм зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргаад, буцаад нийцүүлж байгаа юм байна гэж ойлгоод байна л даа.

Гэхдээ Засгийн газар сая хууль оруулж ирэхдээ Төсвийн тогтвортой байдлын хууль дээр тэр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулаад төсвийн хүрээгээ өөрчилж болно гэдэг энэ эрх зүйн орчныг нээсэнтэй холбогдуулаад бид одоо энэ төсвийн хүрээ, төсвийн тодотголыг хэлэлцэж байгаа шүү дээ.

Тэгэхээр сая 05 дугаар сарын 31-нд Их Хурлаар батлагдсан 2026 оны төсвийн хүрээ чинь сая төсвийн хүрээ, тодотголтой холбогдуулаад тоонууд нь

нийцэх ёстой гэдэг утгаараа бид 2026 оны төсвийн хүрээг сая Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуультай холбогдуулаад хамт мэдүүлсэн байхгүй юу.

Тэгэхээр тоонуудаа нийцүүлэе гэдэг утгаараа. Яагаад гэхээр одоо 05 дугаар сарын 31-нд батлагдсан байгаа төсвийн хүрээний мэдэгдлээр чинь нөгөө алдагдалгүй төсөв батлах, дээрээс нь нүүрсний үнийг чинь 80 доллароор тооцсон. Эдийн засгийн өсөлт 6 хувиар байхаар тооцсон. Батлагдсан төсвийн хүрээн дээрээ ирэх оны төсвийг барих болчихоод байна.

Нүүрсний үнийн тооцоолол чинь 13-аас 30 хувиар өснө гэдгийг тэр Блүүмбергийн терминал дээр байгаа энэ 14 байгууллагын үнийн төсөөлөл дээр энэ чинь улам унана.

Валютын сан чинь 68 доллар гээд үзсэн байна.

Гэтэл бид 05 дугаар сарын 31-нд батлагдсан төсвийн хүрээн дээрээ нүүрсний үнээ 80-аар тооцсон байхад 09 дүгээр сарын 01-нд Засгийн газар төсвөө мэдүүлэхдээ 80 доллароор тооцсон алдагдалгүй төсөв барьж чадахгүй болох гээд байгаа байхгүй юу.

Тийм учраас нийцүүлэе л гэдэг ийм л санал гаргасан.

Гэтэл хуулийн хүрээнд 2026 оны төсөв барихдаа одоо батлагдсан төсвийн хүрээгээрээ явахгүй бол дахиад нөгөө Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан төсвийн хүрээ батлагдсанаас хойш 3 сарын хугацаанд төсөв мэдүүлэхгүй гэдэг заалт чинь хуулийн түгжээ болно гэдэг ийм үндэслэл гараад байна шүү дээ.

Тэгэхээр өчигдөр ажлын хэсэг дээр яриад Засгийн газар хуулиа татаж авах уу, үгүй юу гэдэг асуудлыг ажлын хэсгийн ахлагчаас тавьсан гэж бид ойлгосон. Гэхдээ Засгийн газар энэ төсвийн хүрээгээ татаж авах бололцоогүй юм байна.

Яагаад гэхээр одоо батлагдаж байгаа төсвийн хүрээн дээр чинь нүүрсний үнээ 70-аар бодсон байхад сарын дараа бид 80 байх юм, эдийн засгийн өсөлт 6 байна гээд амьдралгүй юм батлагдаж болохгүй болчихоод байгаа юм л даа.

Тийм учраас нэгэнт Засгийн газар төсвийн хүрээгээ татаж аваагүй байгаа тохиолдолд шууд татаж авсан юм шиг энэ ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй саналын томьёолол хураалгаад, энэ тоонуудыг буцаагаад хуучин руу нь хөрвүүлээд явах гэхээр энэ чинь эхлээд нөгөө төсвөө буцаах санал хураагдаагүй учраас энэ чинь өөрөө хуулийн зөрчил болох юм биш үү.

Хэрвээ ийм тохиолдолд зарчмын зөрүүтэй санал гаргах гэж байвал эхлээд Төсвийн байнгын хороо нөгөө 2026 оны тэр төсвийн хүрээний мэдэгдлийг хууль санаачлагчид нь буцаах гэдэг саналын томьёоллоор санал хураагаад, Их Хурал одоо бүрэн эрхийнхээ хүрээнд энэ төсөл маань бидэн рүү буцчихвал энэ зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор тоонууд нь буцаад нийцүүлээд, тоогоо нийцүүлээд явах нэг гарц харагдаж байна. Их Хурал өөрөө шийднэ.

Үгүй гэвэл шууд үүнийг хураалгана гэхээр чинь одоо бид Их Хуралд өргөн мэдүүлээд хэлэлцээд явж байгаа төсвийн хүрээ чинь байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ саналын томьёоллын Ц.Даваасүрэн дарга хэрвээ хураалгана гэвэл Та ажлын хэсгээс манай өргөсөн байгаа төсвийн хүрээг хуулийн төсөл санаачлагчид нь буцаах. Дэмжигдсэн тохиолдолд энэ зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор тоонуудыг нь нийцүүлэх ийм арга хэмжээ авах л ийм гарц байна шүү дээ.

Ц.Даваасүрэн: Одоо энэ чинь нэг ийм юм үүсчхээд байгаа юм.

Хэрвээ Засгийн газрын өргөн барьснаар төсвийн хүрээний мэдэгдлийг бид ингээд явуулах юм бол та нар 09 сарын 01-нд өргөж болохгүй болчхоод байгаа байхгүй юу. Нөгөө 3 сарын дотор төсөв өргөж болохгүй.

Тэгэхээр ямар төсвөө өргөхгүй байлтай биш. Бүр хачин юм болно шүү дээ.

Тэгэхээр уг нь Засгийн газар яах байсан гэвэл тэр өмнө батлуулсан нөгөө Төсвийн тогтвортой байдлын хуулийн тэр Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орвол энэ заалт хамаарахгүй гээд байгаа дээр үүнийгээ хийж орж ирэх байсан байхгүй юу. Тэгээд Засгийн газар энэ дээр дутуу ажилласан харагдаад байгаа юм.

Тэгэхээр бид одоо ингээд үүнийг чинь хөндөөд явъя гэхээр нөгөө хууль чинь батлагдсан. Чадахгүй болоод байгаа юм. Нөгөө Байнгын хороо хууль санаачилъя гэхээр.

Тэгэхээр энэ хуулийг буцаахаас өөр аргагүй болж байгаа юм. Тэгээд үүний дараагийн санал буцаах санал байгаа. Тэгээд энэ саналыг ингээд хураагаад явчихъя. Үүний дараагийн санал нь. Тайлбар хийсэн шүү дээ.

Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг дэмжье гэсэн саналын томьёолол санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 68.4 хувиар ажлын хэсгийн санал дэмжигдлээ.

Ингээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулсан зарчмын зөрүүтэй саналыг хурааж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал гаргасан юм байна уу? 2 дээр ажлын хэсгээс байхгүй юу? Байхгүй байна. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөл тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Одоо яг нөгөө Н.Учрал гишүүний яриад байгаа хууль шүү.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн хуулийн төслийг хууль санаачлан буцаах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

19 гишүүн санал хураалтад оролцсоноос 14 дэмжиж, 73.7 хувиар энэ санал дэмжигдлээ.

Ингээд энэ хууль буцлаа. Буцаах санал дэмжигдлээ. Чуулганаар шийдэгдэнэ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 14 минут үргэлжилж, 15 цаг 10 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД